

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дугаар сарын 19-ны өдөр 17:00 цагаас 19:05 цагийн хооронд Улаанбаатар хот, компанийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/mandaldaatgal/> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр хуралдав. Санал хураалт болон асуултыг <https://www.stock.mandal.mn/> цахим хаягаар хураав.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Балдангийн ЭНХТҮВШИН

Тооллогын комисс: З.Цэндсүрэн /Комиссын дарга/

Гишүүд: А.Ундрал

Б.Баяржаргал

Л.Насанжаргал

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 36

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 535,797,973 ширхэг

Хурлын ирц: 85.8 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Мандал Даатгал” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2021 оны 03 сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2021 оны 03 сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр 2021 оны 03 сарын 17-ны өдөр, 2021 оны 04 сарын 01-ны өдрүүдэд тус тус мэдээллэснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2021 оны 03 сарын 17-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвэлмэл хэлбэрээр хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2021 оны 04 сарын 01-ны өдрөөр тогтоосоныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон

Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ө.Ганзориг нээлтийн үг хэлсэнээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

2 дугаар асуудал: Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3 дугаар асуудал: Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

4 дүгээр асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

5 дугаар асуудал: Компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үүнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

6 дугаар асуудал: Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

7 дугаар асуудал: ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн 2020 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг товч танилцуулав.

2020 оны орлого үр дүнгийн тайлан: Нийт хураамжийн орлогыг 33.2 тэрбум төгрөг, Орлогод тооцсон хураамж 17.0 тэрбум төгрөг, Нөхөн төлбөр 7.9 тэрбум төгрөг, Хөрөнгө оруулалтын орлого 5.5 тэрбум төгрөг, Үйл ажиллагааны зардал 7.7 тэрбум төгрөг, Цэвэр ашгийг 4.5 тэрбум төгрөгт хүрсэн.

2020 оны санхүүгийн тайлан: Мөнгөн хөрөнгө 33.6 тэрбум төгрөг, Авлага 5.3 тэрбум төгрөг, Эздийн өмч 22.7 тэрбум төгрөг, Өр төлбөр 32.5 тэрбум төгрөг, Нийт хөрөнгө 55.2 тэрбум төгрөгт хүрсэн.

2020 оны ашигт ажиллагааны үзүүлэлт: Хохиролын харьцаа 42%, Нийлмэл харьцаа 95% Эздийн өмчийн өгөөж (ROE) 21%, Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 9% байсан.

“Мандал Даатгал” ХК-ны хувьцааны үзүүлэлтийг танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ны нийт гаргасан хувьцааны тоо 624,301,600 ширхэг, 2020 оны хаалтын ханш 48.0 төгрөг, Зах зээлийн үнэлгээ 30.0 тэрбум төгрөг, 2020 онд нийт 1.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн, 2020 оны өдрийн дундаж арилжаа 4.3 сая төгрөг байсныг танилцуулав.

Даатгалын салбарын 2020 оны тойм: Санхүүгийн үр дүнгээр салбарт эзлэх байр суурийн хувьд Мандал Даатгал нь нийт хураамжийн орлогоор 2-т, нийт хөрөнгө оруулалтын орлогоор 1-т, цэвэр ашгийн хэмжээгээр 1-т, нийт хөрөнгийн хэмжээгээр 1-т, нийт мөнгөн хөрөнгийн хэмжээгээр 1-т тус тус жагсаж байгааг танилцуулав.

2021 оны Бизнес төлөвлөгөө: Нийт хөрөнгө 57,1 тэрбум төгрөг, Мөнгөн хөрөнгө 35,2 тэрбум төгрөг, Нийт хураамжийн орлого 30,0 тэрбум төгрөг, Хөрөнгө оруулалтын орлого 4,5 тэрбум төгрөг, Цэвэр нөхөн төлбөр 7,1 тэрбум төгрөг, Үйл ажиллагааны зардал 7,5 тэрбум төгрөг, Татварын дараах цэвэр ашиг 4,4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөнийг танилцуулав.

2021 оны 1-р улирлын санхүүгийн товч үр дүн: Нийт хөрөнгө 59 тэрбум төгрөг, Мөнгөн хөрөнгө 34,8 тэрбум төгрөг, Нийт хураамжийн орлого 8,2 тэрбум, Хөрөнгө оруулалтын орлого 0,9 тэрбум төгрөг, Цэвэр нөхөн төлбөр 1,4 тэрбум төгрөг, Үйл ажиллагааны зардал 1,6 тэрбум төгрөг, Татварын дараах цэвэр ашиг 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажилласаныг танилцуулав.

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК-ны 2020 оны 10 сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 20/008 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ны 2020 оны Санхүүгийн тайланг батлах хөндлөнгийн аудитын компаниар “Грант Торнтон Аудит” компанийг сонгосон. “Гранд Торнтон Аудит”-ын фирм нь Олон улсын аудитын франчайз бөгөөд “Мандал Даатгал” ХК-ны санхүүгийн тайланг сүүлийн 5 жил хийсэн.

Дүгнэлтийн товч агуулга: Бидний дүгнэлтээр энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн болохыг 2021 оны 03-р сарын 01-ний өдөр баталгаажуулсан байна.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга:

Мандал Даатгал ХК-ийн эрхэм харицагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2020 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна. Мандал Даатгал ХК-ийн ТУЗ нь 2019 оны 12 сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар Мандал Даатгал ХК-ийн 2020 оны Бизнес төлөвлөгөөг хэлэлцсэн баталсан. ТУЗ-ийн баталсан 2020 оны Бизнес төлөвлөгөөний гол зорилго нь компани зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, Олон улсын үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоолгосон анхны компани болох, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх байсан бөгөөд үүний хүрээнд үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, ажилтнуудын ур чадварын сайжруулах гэсэн гурван төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна. 2020 он хэдийгээр Корона вирусээс болж хөл хорио тогтоож, эдийн засгийн хувьд хүнд жил байсан боловч Мандал Даатгал ХК 2020 онд нийт 33,2 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, өмнөх оны мөн үеэс 15% өссөн, татварын дараах цэвэр ашиг 4.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23% буурсан гүйцэтгэлтэй гарлаа.

Эдийн засгийн хямралтай байсан 2020 онд Мандал Даатгал ХК-ийн нөхөн төлбөр өмнөх оноос даруй 64 хувиар өсөж 7,2 тэрбум төгрөгт хүрсэн нь энэ хүнд хэцүү үед Мандал Даатгал ХК даатгуулагчдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа алдалгүй хүргэж байсан гэж үзэж байна.

Компанийн мөнгөн хөрөнгө 28,5 тэрбум төгрөгөөс 33,6 тэрбум төгрөг болж нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 47 хувиар өсч 2020 онд хөрөнгө оруулалтаас 5.5 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Мөн нийт хөрөнгө 55.2 тэрбум төгрөг болж өмнөх оноос 36% өссөн үзүүлэлттэй байна.

Мөн Мандал Даатгал ХК нь 2020 онд олон улсын AM Best агентлагаас BB+ үнэлгээ авсан Монголын анхны компани болсон. Энэ үйл явдал нь Мандал Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигч, харилцагчдын бидэнд итгэсэн итгэлийг бататгаж, бидний ажлын үр дүнг дүгнэсэн явдал болсон. 2020 он хэдийгээр хүнд хэцүү жил байсан боловч Мандал Даатгал ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байгааг танилцуулав.

Түүнчлэн 2018 оны 12 сарын 12-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас томилогдсон ТУЗ нь улирлын хурлаа цаг хугацаанд нь хийж, 2020 онд нийт 12 удаа ээлжит болон уулжит бус хурал хуралдаж, компанийн бизнес төлөвлөгөө батлах, ногдол ашиг олгох зэрэг стратегийн 14 шийдвэрүүдийг гаргасан. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдлийн хороо 6 удаа, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал хороо 3 удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаанд хяналт тавин, ТУЗ-д зөвлөмж өгч ажиллаж байгааг онцолсон.

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2021 оын 02 сарын 18-ны өдрийн ээлжит хурлын 21/001 тоот шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болохыг танилцуулав. Нэгж хувьцаанд 3 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нийт 1,872,904,800 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2021 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөр тогтоосон. Ногдол ашгийг 2021 оны 06 дугаар сарын 30-ний дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах байдлаар хуваарилах болохыг мэдэгдэв.

5 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үүнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн одоогийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2018 оны 12 сарын 12-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 18/006 тоот тогтоолоор 3 жилийн хугацаатай сонгосон. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 2021 оны 12 сарын 12-ны өдөр дуусгавар болох бөгөөд бид 2021 оны 12 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан ТУЗ-ийн гишүүдийг сонгох шаардлага тулгараад байгаа тул ТУЗ-ийн 2021 оны 03 сарын 10-ны өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн бүрэн эрхийг хугацааг хугацаанаас нь өмнө дуусгавар болгон шинээр сонгохоор шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах 6 хүн нэр дэвшисэнийг танилцуулав: Үүнд

а. Ноён	Ө.Ганзориг
б. Хатагтай	Ш.Гантуяа
в. Ноён	О.Ганжолоо
г. Ноён	О.Мөнхжаргал
д. Ноён	Л.Ганзоригт
е. Ноён	Б.Жавхлан

ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах 4 хүн нэр дэвшисэнийг танилцуулав. Үүнд:

а. Ноён	Жэймс Бернард Двайер
б. Ноён	Ж.Дэлгэрсайхан
в. Ноён	Э.Нандинзүрх
г. Ноён	Г.Гантулга

6 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулаж байгаа өөрчлөлтүүдийг танилцуулав. Үүнд:

1. ТУЗ-ийн цалин урамшууллыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулах. Компанийн дүрмийн 7.8.1-р заалт хуучин: ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох гэснийг ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, ТУЗ-ийн цалин урамшууллын хэмжээг тогтоох гэж өөрчлөх
2. Дээрх заалттай холбоотойгоор Компанийн дүрмийн 8.13 -р заалт ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр ХЭХ-ын бүрэн эрхэд хамруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Компанийн дүрмийн 8.12.15-р заалтанд ТУЗ-ийн цалин урамшууллыг тогтоох гэснийг хасах.
3. Компанийн дүрэмд 7.16-р заалтын нэмж оруулах. Үүнд: Компанийн ТУЗ-ийн шийдвэр гарсан, эсхүл ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн эсхүл нийт саналын эрхийн 10 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж буй хувьцаа эзэмшигчээс ТУЗ-д шаардлага гаргасанм тохиолдод Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.
4. Компанийн дүрэмд 13.1.13 заалтын хэмж оруулах. Үүнд: Компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт Санхүү эрхэлсэн захиралыг оруулах.

7 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Компанийн дүрэмд өөрчлөлт орсонтой холбоотойгоор ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Үүнд:

Компанийн ТУЗ-ийн дарга болон ердийн гишүүн, хараат бус гишүүний цалин урамшуулал 154,0 сая төгрөг, Бичиг хэргийн зардал 1,0 сая төгрөг, ТУЗ-ийн хурлын зардал 2,0 сая төгрөг нийт 157,0 сая төгрөгийн төсвийг батлуулахаар танилцуулав.

Асуулт, Хариулт

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлсэнийг зарлаж тооллогын комиссийн даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал явагдаж байгаа тул бүх асуултанд хариулах боломжгүй,

асуултуудийг агууллагын хувьд ижил болон олон давхцсан асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

Асуулт 1:

Мандал Даатгалын нийт хөрөнгө өөрийн хөрөнгөөс хамгийн ихдээ хэд дахин илүү болох боломжтой вэ? Даатгалын компанийн санхүүгийн хөшүүргийн харьцаанд (leverage) хууль эрх зүйн зохицуулалтаар тааз тогтоосон байдаг уу? Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал гэсэн 2 албан тушаалтан байна. Энэ давхардал биш үү. Ажил үүргийн хувиарыг нь тодруулж өгнө үү.

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Жавхлан:

Манай компанийн өөрийн хөрөнгөөр дахин санхүүжилт хийдэггүй, өр төлбөрөөр хөрөнгөө бүрдүүлж явдаггүй, манай нийт актив 55 тэрбум төгрөг байгаа нь өөрийн хөрөнгө, даатгалын нөөц сан болон хойшлогдсон хураамжийн орлогоос бүрдсэн байгаа. Даатгалын компани leverage хийж банк санхүүгийн байгууллагаас зээл авдаггүй байгаа.

Мандал Даатгал ХК өнөөдрийн байдлаар 150 ажилтантай, Удирдлагын багийн гишүүн 8 хүн байгаа, топ удирдлагад Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захиралын орлогч, Ерөнхийлөгч гэсэн албан тушаал байгаа. Гүйцэтгэх захиралын орлогч бол борлуулалт хариуцаж ажилладаг үүнд байгууллагын даатгал, иргэдийн даатгал, харилцагчийн халамж гэх мэт. Харин Ерөнхийлөгч байгууллагын менежментийг буюу арын алба, дэмжих албуудыг хариуцаж ажилладаг. Гүйцэтгэх захирал миний бие компанийн бүхийл үйл ажиллагааг хариуцаж ажилладаг борлуулалт, арын дэмжих алба, бизнес хөгжил, маркетинг, даатгалын бодлого гэх мэт.

Асуулт 2:

Жижиг хувьцаа эзэмшигч нарт компаний 2021 оны үйл ажиллагаанд баримтлах бизнесийн стратеги төлөвлөгөөнөөс мэдээлэл өгөх боломж байна уу. Томоохон хэмжээний хэлцэл гүйлгээний талаар ямар хугацааны давтамжтай мэдээлэл өгдөг вэ.

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Жавхлан:

Компаний тухай хуулиар сонирхолын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэлийг тухай бүр ТУЗ-д танилцуулж зөвшөөрөл авч батлуулдаг. Компаний тухай хуулиар их хэмжээний хэлцэл гэдгийг Компанийн сүүлийн санхүүгийн тайлангаарх активын 25%-иас дээш дүнтэй гэж заасан байдаг бөгөөд манай компанийн хувьд 55,0 тэрбум төгрөгийн активын 25% гэхээр 13 тэрбум төгрөгөөс дээш хэлцэл болдог, гэхдээ бид эрх мэдлүүдийг хувааж өгсөн байдаг, Гүйцэтгэх захиралын эрх мэдлийг зааж өгөөд түүнээс давсан тохиолдолд ТУЗ-д танилцуулж шийдвэр гаргаад явдаг байгаа.

Жижиг хувьцаа эзэмшигчид бизнес төлөвлөгөөг танилцуулж өгнө үү гэсэн байна. 2021 онд бид нөхцөл байдал хүнд байгаа учир хамгаалах тактик баримталж байгаа, тодорхойгүй маш олон хүчин зүйл байгаа учир. Та бүхэнд эхний улиралын санхүүгийн үр дүнг танилцуулсан. Монгол улсад даатгалын нэвчилт харьцангуй бага байдаг нь харагдаж байна. Даатгуулах шаардлагатай хүмүүс нь даатгуулдаг, сайн дураар даатгуулдаг хүн даатгалаа тандаг юм байна гэж харж байгаа. Тиймээс бид бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулъя, цахим үйлчилгээг илүү сайжруулах, дотоод процесс сайжруулах гэх мэт ажилууд дээр зорьж ажиллаж байгаа.

Асуулт 3:

Berkshire Hathaway болон Markel өөрсдийн float хөрөнгийг гол төлөв урт хугацааны, өндөр өгөөжтэй хувьцаанд хөрөнгө оруулдаг? Мандал Даатгал цаашид энэ загвар уруу орох боломж,

магадлал хэр вэ? Хорооны журам өөрчлөгдөх болов уу? Ийм тохиолдолд Мандалын Warren Buffett, Tom Gayner хэн байх вэ?

Компанийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны талаар боломжийн хэмжээнд дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү: хэн хариуцаж хэрэгжүүлж байгаа, аль салбарт түлхүү анхаарал хандуулж байгаа талаар г.м

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Жавхлан:

2020 онд бид хөрөнгө оруулалтын нэгж байгуулсан. Түүний үр дүнд хөрөнгө оруулалтын орлого өмнөх жилээс 50 гаруй хувиар өссөн байгаа. Хөрөнгө оруулалтын бодлогын хувьд бид нээлттэй компани, хөрөнгө оруулж байгаа мөнгө маань даатгуулагч болон хувьцаа эзэмшигчдийн мөнгө гэдэг утгаар эрсдлийг нилээн судалж хөрөнгө оруулалт хийдэг. Бид хувьцаа болон үнэт цаас гэхээс илүүтэй тогтмол хүүтэй хөрөнгө оруулалтыг түлхүү хийж байгаа. Манай хөрөнгө оруулалт хийсэн байгууллагуудын 80% нь олон улсын үнэлгээ хийлгэсэн банк болон засгийн газрын бонд байгаа.

Асуулт 4:

Мандалын өрсөлдөгчдөөсөө ялгарах давуу тал нь юу вэ? Мандалын хамгийн хүчтэй өрсөлдөгч хэн бэ? Харилцагчдаа хэрхэн алдахгүй барих вэ? Lock in хийх боломж бий юу? Retention rate хэр түвшинд буй вэ? Даатгал нь commodity service. Хэрхэн ялгарах вэ? Өндөр өсөлтөө цаашид хэрхэн хадгалах вэ?

Хариулт Гүйцэтгэх захирал Б.Жавхлан:

Монгол улсын даатгалын нийт хураамжийн орлогыг Дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулаад үзэхэд 0,5% байгаа нь даатгалын салбар цаашид одоогийн байгаагаас 10-аас 12 дахин хөгжих боломжтой гэж харж байгаа. Мандал Даатгал ХК үүсгэн байгуулагдаад 10 жил боллоо энэ хугацаанд Санхүүгийн үзүүлэлт болон бусад үзүүлэлтээрээ тэргүүлэгч компани нь болсон. Бид бусад даатгалын компаниудыг өрсөлдөгч гэхээс илүүтэй энэ салбарт хамтран зүтгэгч даатгалын салбарыг хамтран хөгжүүлэгч гэж хардаг.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Мандал Даатгал” ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,749,948 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХУГАЦААНААС НЬ ӨМНӨ ДУУСГАВАР БОЛГОХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,691,610 ширхэг хувьцааны санал буюу 99,99 хувийн саналаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгоход өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 4,808,255,859 ширхэг саналыг дараах байдлаар ТУЗ-ийн нэр дэвшигч гишүүдэд өгсөнөөр батлав. /Кумулятив аргаар санал хураасан/ Үүнд:

Ердийн гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив саналын тоо	Хувь
Өлзийбаяр овогтой ГАНЗОРИГ	540,343,473	11.21 %
Батсайхан овогтой ЖАВХЛАН	538,163,417	11.17 %
Очирпүрэв овогтой ГАНЖОЛОО	532,033,237	11.04 %
Шаравпэлжээ овогтой ГАНТУЯА	532,022,620	11.04 %
Лувсанжамба овогтой ГАНЗОРИГТ	531,645,197	11.03 %
Отгон овогтой МӨНХЖАРГАЛ	531,643,917	11.03 %

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив саналын тоо	Хувь
Жамсрандорж овогтой ДЭЛГЭРСАЙХАН	537,645,353	11.16 %
Жэймс Бернارد ДВАЙЕР	532,134,230	11.04 %
Гарамдорж овогтой ГАНТУЛГА	531,971,971	11.04 %
Эрдэнэбат овогтой НАНДИНЗҮРХ	652,444	0.01 %

КОМПАНИЙН ДҮРМИЙН 7.8.1-Р ЗҮЙЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн дүрмийн 7.8.1-р зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 7.8.1-р зүйлд нэмэлт өөрчлөлт оруулахыг батлав.

КОМПАНИЙН ДҮРМИЙН 8.13.15-Р ЗҮЙЛИЙГ ХАСАХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн дүрмийн 8.13.15-р зүйлийг хасахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 8.13.15-р зүйлийг хасахыг батлав

КОМПАНИЙН ДҮРМИЙН 7.16-Р ЗҮЙЛИЙГ НЭМЭХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн дүрмийн 7.16-р зүйлийг нэмэхэд өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 7.16-р зүйлийг нэмэхийг батлав.

**КОМПАНИЙН ДҮРМИЙН 13.1.13-Р ЗҮЙЛИЙГ НЭМЭХ АСУУДЛААР САНАЛ
ХУРААСАН ДҮН:**

Компанийн дүрмийн 13.1.13-р зүйлийг нэмэхэд өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 13.1.13-р зүйлийг нэмэхийг батлав.

**КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ
АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:**

ТУЗ-ийн 2021 үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Мандал Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга цахимаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хаалтыг үгийг хэлсэнээр 19 цаг 05 минутанд хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЙСӨН:

Б.ЭНХТҮВШИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН:

Ө.ГАНЗОРИГ

Хурлын дарга